



**МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/44

Улаанбаатар хот

Ачилт, буулгалт, хадгалалтын болон гаалийн хяналтын
талбайн ашиглалтын төлбөр тогтоох тухай

Төмөр замын тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 18 дугаар зүйлийн 18.3.3, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.11-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хандгайт, Төмөртэй өртөөнд байрлах тус компанийн эзэмшлийн ачилт, буулгалт, хадгалалтын болон гаалийн хяналтын талбайн ашиглалтын хөлсний хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн харилцааны ачаа тээвэрлэлтийн тариф хэрэглэх дүрэм"-ийн 18 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Ашиглалтын хөлсний талаар харилцагч байгууллагуудад мэдэгдэж, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж ажиллахыг Тээвэр, ложистикийн төлөвлөлтийн газрын дарга /Г.Цолмонбаяр/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг, Санхүү нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга /Г.Өлзийбаяр/, Эдийн засаг, хөрөнгө оруулалтын газрын дарга /Д.Банзрагч/ нарт тус тус даалгасугай.

5. Тушаалыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ОТГОНСҮХ

20240318

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
А/44..... дугаар тушаалын хавсралт



Ачилт, буулгалт, хадгалалтын болон гаалийн хяналтын
талбайн ашиглалтын хөлс /төлбөр/

1. Хандгайт өртөө

Талбай	Талбайн 1 сарын хөлс /төгрөг/
Ачилт, буулгалт, хадгалалтын 1-р талбай	8,500,000
Ачилт, буулгалт, хадгалалтын 2-р талбай	8,500,000
Ачилт, буулгалт, хадгалалтын 3-р талбай	8,500,000
Ачилт, буулгалт, хадгалалтын 4-р талбай	8,500,000

2. Төмөртэй өртөө

Талбай	Талбайн 1 сарын хөлс /төгрөг/
Гаалийн хяналтын 1-р талбай	34,000,000
Гаалийн хяналтын 2-р талбай	11,300,000
Гаалийн хяналтын 3-р талбай	11,300,000
Гаалийн хяналтын 4-р талбай	11,300,000

---oOo---